

“22-р БААЗ” ХК

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт болов.

Улаанбаатар хот
2022 он

**“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Энх-тайвны өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод хуралдана.

- | | |
|--|-------|
| 1. Хурал зохион байгуулах комиссын дарга нээж үг хэлэх | 14:00 |
| 2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах. | 14:10 |
| 3. Компанийн 2021 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан З.Туяа танилцуулах. | 14:20 |
| 4. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт. | 14:30 |
| 5. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах. | 14:40 |
| 6. Компанийн харилцах дансны гүйлгээ хийх, цахим банкны үйлчилгээ авах гүйлгээ хийх, Хаан банкинд данс нээлгэх болон гүйлгээ хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох. | 14:50 |
| 7. Компанийн мөнгө хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай. | 15:00 |
| 8. Дулааны шугам засвар, бохирын шугамын засварууд хийх. | 15:10 |
| 9. Шинэ гарц гаргах тухай | 15:20 |
| 10. Бусад. | 15:30 |
| 11. Хурлыг хааж үг хэлэх: ТУЗ-ийн дарга Л.Гүндэгмаа | 15:40 |

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 3.Туул 88101625

Е-мэйл хаяг: 22г.baaz@gmail.com

**“22-Р БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“22-р Бааз” ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан.
- Компанийн 2021 оны санхүүгийн тайлан.
- Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр.
- Компанийн 2021 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоол болон хавсралтууд.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал авах хуудасны загвар.
- Бусад.

**2022.04.29 14:00 минут 22-р Бааз ХК-ийн
ээлжит хурлын тэмдэглэл ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

22-р Бааз ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал БЗД 8-р хороо 22-р Бааз ХК-ийн байранд 101 тоот-д хуралдав. Хурал 14:00 цагт эхлэв.

Хуралд хувьцаа эзэмшигчдээс:

- “Монгол СекьюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- “Чингис Хаан Секьюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар/Гүйцэтгэх захирал/

Нийт 1,945,050 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 73,3 хувийг эзэмшигчид хуралд оролцов.

ТУЗ-ийн гишүүдээс:

- Л.Гүндэгмаа /ТУЗ-ийн дарга/
- П.Эрдэнэчулуун
- Т.Зоригтбаатар
- З.Номундарь
- Т.Эрдэнэбаатар
- Б.Баярсайхан
- Ю.Туяацэцэг
- А.Баатаржав
- Ц.Энхтуяа нар оролцов

Мөн хуралд:

- 22-р Бааз ХК-ийн нягтлан бодогч З.Туяа
- Тооллогын комиссын дарга Т.Халиун
- Тооллогын комиссын гишүүн М.Нэргүй
- Хурлын нарын бичгийн дарга З.Туул нар оролцов

Хурлыг Л.Гүндэгмаа удирдав. Хурлын дэг болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцуулав.

Л.Гүндэгмаа: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья.

Тооллогын комиссын дарга Т.Халиунаа ирцийг танилцуулан тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц

73,3% байгаа тул Монгол Улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Л.Гүндэгмаа: Сайн байцгаана уу хуралдаа оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд хурлын дэгийн дагуу та бүхэндээ хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулъя.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулна.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан З.Туяа танилцуулна.
3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлтийг мөн нягтлан танилцуулна.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг ТУЗ-ийн дарга Гүндэгмаа миний бие танилцуулна.
5. Компанийн харилцах дансны гүйлгээ хийх, цахим банкны үйлчилгээ авах гүйлгээ хийх, Хаан банкинд данс нээлгэх болон гүйлгээ хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай асуудлыг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулна.
6. Компанийн мөнгө хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай мөн Т.Зоригтбаатар захирал танилцуулна.
7. Дулааны шугам засвар, бохирын шугамын засварууд хийх тухай асуудлыг мөн гүйцэтгэх захирал танилцуулна.
8. Шинэ гарц гаргах тухай Т.Зоригтбаатар захирал танилцуулж тайлбарлана.
9. Бусад.

За ингээд хэлэлцэх дарааллын дагуу гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар та үйл ажиллагааны тайланг танилцуулна уу.

Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар: Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан та бүхний гар дээр байна. Жилийн үйл ажиллагааны тайланг аудитын тайлантай хамт 04.01-ний дотор бид нар мөн СЗХ, ХБ-д хүргүүлдэг байгаа. Ингээд та бүхэнд уншиж танилцуулъя.

Л.Зоригтбаатар 22-р Бааз ХК-ийн үйл ажиллагааны тайланг уншиж танилцуулав.

Л.Гүндэгмаа: Дараагийн асуудлуудыг Ерөнхий нягтлан З.Туяа танилцуулна.

З.Туяа: Сайн байцгаана уу. Компанийн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

Ерөнхий нягтлан З.Туяа Санхүүгийн тайлан болон, аудитын дүгнэлтийг уншиж танилцуулав.

Л.Гүндэгмаа: Компанийн Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг та бүхэндээ танилцуулъя.

Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг ТУЗ-ын дарга Л.Гүндэгмаа уншиж танилцуулав.

Л.Гүндэгмаа: Дараагийн асуудлуудыг гүйцэтгэх захирал Зоригтбаатар та бүхэнд танилцуулах болно.

Т.Зоригтбаатар: Компанийн хувьд нилээд тулгамдсан асуудал болоод байгаа дараагийн асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Хувьцаа эзэмшигчид маань энэ асуудал дээр дэмжинэ гэдэгт найдаж байна. Энэ асуудал нь Компанийн харилцах дансны гүйлгээ хийх, цахим банкны үйлчилгээ авах мөн гүйлгээ хийх эрх болон Хаан банкинд данс нээлгэх болон гүйлгээ хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай асуудал юм. Бидэнд тулгамдаад байгаа хамгийн хүнд асуудал нь компанийн харилцах дансны гүйлгээ хийх эрхгүй учир ихэнхи

төлбөр тооцоо кассаар явдаг нь нилээд хүндрэл учруулдаг. Ийм учраас компанийн дансны гүйлгээ хийх эрх болон цахим банкны үйлчилгээ авах эрхийг яаралтай авах хэрэгтэй байгаа юм. Мөн ихэнхи түрээслэгч нар маань Хаан банкны дансанд төлбөрөө шилжүүлэх сонирхолтой байдаг. Үүнээс үүдээд бид хэд хэдэн удаа Хаан банкинд хандсан хэдий ч хувьцаат компанийн онцлогоос шалтгаалан хувьцаа эзэмшигчид маань зөвшөөрөөгүй тохиолдолд бид нээлгэж чадахгүй эрх авч чадахгүй байгаад байна. Учир нь эдгээр эрхүүд олгогдох эсэх нь дээд эрхтэй хувьцаа эзэмшигчидийн зөвшөөрөл хэрэгтэй гэж банкууд үзэж татгалзсан хариу өгөөд байсан. Компанийн ажилчдын цалин үйл ажиллагааны зардал зэрэг төлбөр тооцоог хийхийн тулд зарим тохиолдолд заавал банкуу захирал өөрийн биеэр очиж шилжүүлэг хийх шаардлага гардаг. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хүндрэлгүй, саадгүй явуулахад энэ асуудлууд нь ихээхэн чухал байгаа учир хувьцаа эзэмшигчид та бүхэн дэмжиж санал өгнө гэж найдаж байна.

За дараагийн хэлэлцэх асуудал бол Компанийн мөнгө хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай байгаа бөгөөд энэ асуудал нь өнөөх л данс нээлгэхтэй холбогдож гарч буй асуудлын нэг. Энэ нь нэрнээсээ их сүртэй уншигдаж байж магад гэхдээ компанийн дансан дахь гүйлгээг цахимаар хийхэд тулгарч байгаа асуудал дээр биднээс банк хөрөнгө мөнгийг захиран зарцуулах эрх гүйцэтгэх захиралд байхгүй учир цахимаар гүйлгээ хийх эрх олгох боломжгүй гэж үзсэн. Дээд эрх нь хувьцаа эзэмшигчид учраас хурлаараа эрхийг нь олгож байж тэр эрх нь олгогдоно гэдэг хариу өгсөн. Нилээн хэдэн удаа банкин дээрээ уулзаж албан бичгээр хүсэлтээ өгч тэр байтугай манай ТУЗ хуралдаж захирлын эрх мэдлийн хэм хэмжээг тогтоох бүрэн эрхтэй гэж заасныхаа дагуу эрхийг захиралд олгох тогтоол хүртэл гаргасан боловч зөвхөн ХЭХ-аар зөвшөөрсөн тохиолдолд боломжтой гэсэн учир энэ асуудлыг бид оруулахаас өөр арга байгаагүй. Зөвхөн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулахад л бидэнд цахимаар гүйлгээ хийх эрх зайлшгүй хэрэгтэй байгааг та бүхэн ойлгож байгаа байх.

Дараагийн бас нэгэн тулгамдаад буй асуудал бол дулааны шугам засвар болон бохирын шугамын засвар хийх асуудал. Түрүү жил бид байгаа нөөц бололцоогоо ашиглаад Узелийн иж бүрэн засварийг хийж шинэ дулааны тоолуур тавьсан, гэсэн хэдий ч дулааны шугамнууд маань маш их мууджээ. Тавьснаас хойш 17, 18 жил ойролцоогоор болж байх шиг байна. 2021 онд 2 ч удаа дулааны шугам цоорч гэмтэж гэмтлийг бид нар дор бүрнээ засварлаж янзалсан. Энэ маягаараа засвар хийлгүй өнжвөл дараа өвөл бас гэмтэл гарч нилээдгүй засвар хийгдэх шинжтэй байна. Тиймээс бид дулааны шугамын засварыг халаалт зогсмогц эхлүүлэхээр төлөвлөөд байгаа. Орж ирсэн орлогуудыг ер нь засварын ажилруу голчлон зарцуулах төлөвлөгөөтэй байна. Энэ мэтчилэн төлөвлөгөө гаргаж энэ жилдээ засваруудыг хийж дуусгах төлөвлөгөөтэй байна.

За мөн манай дараагийн чухал асуудал бол гарц гаргах асуудал. Ковидын нөхцөл байдал намжиж түрээслэгчдийн хувьд харьцангуй боломжийн таатай нөхцөл бүрдэж байгаатай холбогдуулан манай түрээсийн орлого нэмэгдэх хандлагатай байгаа. Бид орчин нөхцөлөө сайжруулж газрын төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна. Үүнтэй уялдуулаад Тэнгэр плазацийн талаар дахин нэг гарц гаргахаар төлөвлөсөн. Тэгвэл хойгуурх түрээслэгчдийг тухайн гарцаар зорчуулах боломжтой болно. Ингэснээр дулааны шугамын засвараа хийх боломжтой болно. Мөн цаашдаа дулааны шугамын эвдрэл гэмтэл ч бага байна гэж тооцоолоод байгаа юм. Учир нь манай түрээслэгчдийн дийлэнхи нь том оврын шланз машинаар үйл ажиллагаа явуулдаг байнга хүнд даацын машинууд явдаг учир түүнээс шалтгаалсан эвдрэл гэмтэл их байна гэж дүгнэсэн. Энэ асуудлыг мөн та бүхэн дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. За ингээд миний танилцуулах асуудлууд боллоо.

Л.Гүндэгмаа: Зоригтбаатар захиралд баярлалаа. Манай ХЭХ-аар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дууслаа. Хуралд оролцож буй та бүхэндээ баярлалаа. Компанийн хувьд цар тахалын асуудал намжиж гаднаас мөн хөрөнгө оруулагчид ирэх таатай нөхцөл байдал үүсч байгааг хэлэхэд мөн таатай байна. Ингээд та бүхнээс санал сэтгэгдэл байвал нээлттэй.

З.Номундарь: Саналуудыг ер нь сонслоо, ойлголоо урсгал засварын ажлууд буюу мэдээж хийх зайлшгүй шаардлагатай эдгээр засваруудыг бол мэдээж бүрэн дэмжиж байна. Татгалзаад байх зүйл алга. Энэ жил мөн гадны хөрөнгө оруулагчдыг татах төсөл хөтөлбөрийн ажлыг эхлүүлмээр байна. Хэдий болтол ийм маягаар явах билээ. Цаашдаа ХЭХ хурал дээр том төсөл хөтөлбөр хэлэлцдэг болоосой гэж хүсч байна. Газрын үнэ өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Манай газар байршил хотын төвд шахуу ороод байна. Эдгээр нөөц бололцоонуудаа хараад цаашид үйл ажиллагаагаа өргөтгөх тал дээр анхаарч ажиллаасай гэж хүсэх байна. Өнөөдөр хэлэлцэж буй асуудлууд дээр татгалзаад байх зүйл алга. Дэмжиж байна.

Т.Эрдэнэбаатар: Нийт хэлэлцэж буй асуудлуудыг дэмжиж байна. Татгалзах зүйл алга. Мөн хэлэх нэг санал байна. Манай компани цаашид хувьцаа гаргаж санхүүжилт босгох бүрэн боломжтой. Яагаад энэ давуу талаа харахгүй байна вэ. Хувьцааны зах зээл өдрөөс өдөрт өргөжин тэлж байна. Сайн багтай болж хувьцаагаар мөнгө босгож өмнө нь хурал дээр ярьж байсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлвэл саадгүй санагдах юм. Энэ саналыг бодож үзээрэй гэж хүсэх байна. Жил болгоны хурал дээр энгийн зүйл ярьмааргүй байна. Ахуйн асуудлуудаасаа салаад томоохон хөрөнгө оруулалт татаж том асуудал ярьдаг болмоор байна. Бидэнд боломж нь байгаа.

Т.Зоригтбаатар: Таны хэлж буй саналыг бүрэн дэмжиж байна.

Л.Гүндэгмаа: Өөр санал хэлэх болон асуулт асуух хүн байна уу?

З.Номундарь: Цар тахлын хүндхэн нөхцөл байдал намжиж байгаа болон бизнесийн таатай орчин эхлэж байгаа үеийг л бид алдалгүй ашигламаар байна.

Ц.Энхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ХЭХ-аар хэлэлцэж буй асуудлуудыг сонслоо татгалзаад байх зүйл алга бүрэн дэмжиж байна. Манай гол хувьцаа эзэмшигч болох Номундарь захирлын саналыг бүрэн дэмжиж байна. Бидэнд цар тахлын хүндхэн нөхцөл байдлыг давах амаргүй байсныг мэдээж ойлгож байна. Гэхдээ одоо цаашид гадны хөрөнгө оруулагчдыг татаж өмнө нь яригдаж байсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх цаг иржээ гэж харж байна. Тиймээс энэ тал дээр анхаарлаа хандуулаарай гэж хүсэх байна. Их олон жил бид ярьж сууцгаалаа компанийнхаа үр ашгийг хүртэж эхлэх өдөр тун удахгүй гэж найдаж байна.

Т.Зоригтбаатар: Та бүхний саналыг ойлголоо.

А.Баатаржав: Манайх одоог хүртэл дансны гүйлгээ хийх эрхээ аваагүй байсан хэрэг үү?

Т.Зоригтбаатар: Тийм гэж ойлгож болно. Өмнө 2 жилд цар тахлын байдлаас болоод бид хойшлуулсаар ирсэн. Хувьцаат компанийн онцлогоос шалтгаалаад яалт ч байхгүй бид үйл ажиллагаагаа өөрсдийн нөхцөл байдалдаа тохируулан ажилласаар ирсэн.

Ц.Энхтуяа: Түүрү жил яригдаж байсан зээл авч барилга барих асуудал юу болсон бэ? Мөн л ХЭХ –аар ярилцаад аятайхан төсөл эхлэх нь гээд дэмжиж санал өгч байсан ч нам жим болчихсон?

Т.Зоригтбаатар: Тухайн үедээ ковидын нөхцөл байдлаас шалтгаалаад мөн хил гаалийн асуудал гарч эхэлсэнтэй холбоотой бид зээлээ аваагүй. Барилгын материалын үнэ ч нилээд өсөөд эхэлсэн. Буух үед нь эхлүүлэх бодолтой байсан ч хил гааль маань нилээн

хүндхэн болоод бид тэр төслийг хойшлуулсан байгаа. Энэ жилдээ урсгал засвар юмнуудаа хийгээд дараа жилээс төлөвлөсөн нилээдгүй ажлууд байгаа.

Хурлын дарга: Нэмж асуулт асуух тодруулах, санал хэлэх хүн байна уу?

За нэмж санал хэлэх хүн гараагүй учир санал хураалтдаа орьё гэж бодож байна. Та бүхний өмнө саналын хуудас байгаа.

Тооллогын комиссын дарга Т.Халиунаа хурлаар хэлэлцсэн асуудлуудыг нэгбүрчлэн асууж санал хураалт явуулав.

Санал хураалт.

1. **“Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан”**-тай танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
 - “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
2. **“Компанийн 2021 оны санхүүгийн тайлан”**-тай танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
 - “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
3. **“Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт”**-тэй танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
 - “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
4. **“Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр”**- тэй танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
 - “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/

- Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
5. **“Компанийн харилцах дансны гүйлгээ хийх, цахим банкны үйлчилгээ авах гүйлгээ хийх, Хаан банкинд данс нээлгэх болон гүйлгээ хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай”-тай** танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
- “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
6. **“Компанийн мөнгө хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох тухай”-тай** танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
- “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
7. **“Дулааны шугам засвар, бохирын шугамын засварууд хийх тухай” асуудалтай** танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
- “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/
8. **“Шинэ гарц гаргах тухай”-тай** танилцаж хувьцаа эзэмшигчдийн 73,3 хувь буюу 1,945,050 саналаар дэмжиж зөвшөөрөв.
- “Монгол СекюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
 - Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
 - Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/

- 3.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /өөрийн биеэр/
- “Чингис Хаан Секюритиес” 56,870 ширхэг хувьцааны саналаар зөвшөөрөв /Гүйцэтгэх захирал/

Санал хураалт дуусч нийт 8 асуудал хэлэлцсэнээс асуудал тус бүрээр санал хураалт явуулж асуудал тус бүр 100 хувийн саналаар буюу хувьцаа эзэмшигчдийн 1,945,050 ширхэг саналаар /73,3%/ батлав.

ХУРЛЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Л.ГҮНДЭГМАА
З.ТУУЛ